



ХАНБОГД СУМЫН ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



АГУУЛГА

Мэндчилгээ

I БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ

1. Зөвлөлийн удирдлага
2. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн
3. Гурван талт зөвлөлийн 2025 оны онцлох ажил
4. Зохион байгуулсан хурал, сургалт, арга хэмжээнүүд
5. Цаг үеийн мэдээллийн хүртээмж
6. Гурван талт зөвлөлийн сайн туршлага
7. Судалгааны үр дүнгүүд
8. Хаалтын аудит
9. Хараат бус нарийн бичгийн байгууллага
10. Мэдээллийн ил тод байдал
11. Санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал

II БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

1. Хөндлөнгийн үнэлгээ
2. Тайлант онд зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлсэн ажлууд
 - 2.1. Усан хангамж
 - 2.2. “Ундайн өв соёл” төсөл
 - 2.2.1. Хөв цөөрөм
 - 2.3. Нөхөн сэргээлтийн ажлууд
 - 2.4.1. Төлөгийн тал
 - 2.4.2. Уст баг мод
 - 2.4.3. Бор-Овоогийн задгай
 - 2.5. Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ 10 ЖИЛИЙН ОЙ МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм уншигч та бүхэндээ Гурван талт зөвлөлийн хамт олон 2025 оны үйл ажиллагааны үр дүн, ололт амжилтаа багтаасан тайлангаа өргөн барьж буй энэ бахдам мөчид чин сэтгэлийн халуун мэнд дэвшүүлж байна. Бид өнгөрсөн он жилүүдийн хамтын ажлынхаа үр дүнг дүгнэж, ирээдүйн зорилго, үүргээ илүү тодорхой болгож байна.

2025 онд Ханбогд суманд дэд бүтэц, зам тээвэр, бүтээн байгуулалтын олон ажил өрнөж, сумын өнгө төрх шинэ шатанд гарч байна. Эдгээр бүтээн байгуулалт нь төрийн бодлого, хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжиж буй ч, малчид, иргэдийн дуу хоолойг сонсож, санал хүсэлтийг зөвшилцлийн замаар шийдвэрлэхэд Гурван талт зөвлөлийн үүрэг оролцоо орон нутгийн итгэл, ойлголцлын бат бэх тулгуур хэвээр байна.

“2025 он бол Гурван талт зөвлөл байгуулагдсаны 10 жилийн ой тохиож буй онцлогтой жил байлаа. Малчид, орон нутаг, компанийн гурван талын хамтын ажиллагааг институтийн түвшинд бэхжүүлж, итгэлцэлд суурилсан шийдэл гаргах соёлыг төлөвшүүлсэн энэ арван жил нь Ханбогдын хөгжлийн үнэт хөрөнгө болон үлдэж байна. Энэхүү түүхэн хугацаанд олон сорилт, олон шийдэл, олон сургамж хуримтлагдаж, өнөөдрийн бидний хамтын амжилтын суурь болсон гэдгийг онцлон дурдахад таатай байна.”

Малчдын гомдол барагдуулах 1, 2 дугаар гэрээний хэрэгжилтийн хүрээнд зарим томоохон төслүүд одоогоор бүрэн хэрэгжээгүй байгаа боловч эдгээр нь урт хугацааны судалгаа, тооцоо, хөрөнгө санхүүгийн бэлтгэл их шаардсан, стратегийн шинжтэй ажил юм. Энэ нь зөвхөн нэг жилийн ажлын хүрээнд бус, ирээдүйн олон жилийн хамтын хөгжлийн суурь болох төслүүд гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Мөн энэ онд Ханбогд сумын 4 багийн анхан шатны хоршооноос бүрдсэн “Галбын говийн торгон сүрэг” дундын хоршоотой санамж бичиг байгуулж, хамтран хэрэгжүүлэх “махны чиглэлийн өсвөр үхэр бордох”, “Ингэний сүү бэлтгэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх”, “хонины ноосон бордоо бэлтгэх” гэсэн гурван томоохон төслийн эхлэлийг тавьсан нь мал аж ахуйн салбарт шинэлэг, тогтвортой үйлдвэрлэлд чиглэсэн чухал алхам боллоо.

Энэ бүхэн нь зөвхөн байгууллагын бүс, хамтын хүч, иргэдийн оролцоо, итгэлцэл дээр тулгуурласан бодит үр дүн юм. Ирэх онд бид энэхүү хамтын зарчмаа улам гүнзгийрүүлж, аливаа асуудлыг яриа, зөвшилцөл, ойлголцлын хүрээнд шийдвэрлэж, Ханбогдын хөгжлийн төлөө хамтдаа хичээн зүтгэх болно.

Хамтын хүч үргэлж итгэл төрүүлдэг.

Хамтдаа хөгжиж, хамтдаа бүтээе!

Гурван талт зөвлөлийн удирдах нэгжийн гишүүд



Б.АЛТАНГЭРЭЛ

Гурван талт зөвлөлийн удирдах нэгжийн гишүүн, Ханбогд сумын Засаг даргын орлогч



Ч.НАМНАНСҮРЭН

Гурван талт зөвлөлийн удирдах нэгжийн гишүүн, Ханбогд сумын Жавхлант багийн малчдын төлөөлөл



С.ДОРЖДЭРЭМ

Гурван талт зөвлөлийн ахлагч, “Оюу толгой” ХХК-ийн орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг түншлэлийн менежер

01 ЗАСАГЛАЛ

1.1 ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА

Гурван талт зөвлөлийн дүрэмд зааснаар Зөвлөлийн шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Түүнчлэн Зөвлөлийн ахлагчаар талуудыг ахалж буй гишүүд жил бүрээр ээлжлэн ажиллах дүрмийн зохицуулалттай. Дүрмийн дагуу 2025 оны 6 дугаар сараас эхлэн “Оюу толгой” ХХК-ийн төлөөллийн ахлагч, Орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг, түншлэлийн менежер С.Дорждэрэм зөвлөлийн даргаар ажиллаж байна.

ГТЗ-ийн Удирдах нэгжийн бүрэлдэхүүнд орон нутгийн Засаг захиргааны төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Засаг даргын орлогч Б.Алтангэрэл, Малчдын төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Жавхлант багийн малчдын төлөөлөл Ч.Намнансүрэн нар тус тус ажиллаж байна. 2025 онд зөвлөл Хараат бус нарийн бичгийн байгууллага болох Хөгжлийн Шийдэл ТББ-ын дэмжлэгийг авч ажиллаа.

1.2 ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

“Оюу толгой” ХХК-ийн төлөөлөл

С.Дорждэрэм /Орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг, түншлэлийн менежер/

Л.Мөнх-Оргил /Уурхайн үйл ажиллагаа хариуцсан ерөнхий зөвлөх/

Т.Самданжигмэд /Байгаль орчны хэлтсийн менежер/

П.Золбуянхишиг /Орон нутгийн харилцааны хэлтсийн мэргэжилтэн/

Д.Саян /Орон нутгийн харилцааны хэлтсийн мэргэжилтэн/

Орон нутгийн Засаг захиргааны төлөөлөл

Б.Алтангэрэл /Ханбогд сумын Засаг даргын орлогч/

Э.Жамбалсанжид /Ханбогд сумын Жавхлант багийн Засаг дарга/

Ж.Отгончимэг /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/

М.Сүглэгмаа /Ханбогд сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн/

Малчдын төлөөлөл

Жавхлант багийн малчдын төлөөлөл: Ч.Намнансүрэн, Н.Ширнэн, Э.Сүрэнхорол

Баян багийн малчдын төлөөлөл: М.Батхүү, Р.Бадамдорж, Х.Энхбат

Номгон багийн малчдын төлөөлөл: Х.Далантай, Ч.Сувдаа, У.Гантөмөр

Гавилууд багийн малчдын төлөөлөл: Ч.Одмаа, Д.Эрдэнэцэцэг, З.Цогбаяр



Гурван талт зөвлөлийн гишүүд

1.3 ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

Өмнөговь аймгийн Ханбогд суманд 2025 оны намар малчдын амьжиргааг дэмжих, орон нутгийн эдийн засгийг шинэ шатанд гаргах чухал алхам хийгдлээ. Гурван талт зөвлөлийн шийдвэрээр, малчдын гомдлыг барагдуулах гэрээний хүрээнд хэрэгжих Нийтийн нөхөн олговрын төслүүдийг нутгийн малчдын өөрсдийн байгуулсан “Галбын говийн торгон сүрэг” дундын хоршоо хариуцан хэрэгжүүлэхээр болсон нь хамтын оролцоо, хариуцлагын бодит жишээ болов.

2025 оны 10-р сарын 14-нд Ханбогд сумын Засаг дарга, дундын хоршоо болон “Оюу толгой” компаний төлөөлөл гурван талт хамтын ажиллагааны Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, мал аж ахуйн тогтвортой хөгжлийн шинэ үеийг эхлүүллээ. Уг санамж бичигт “махны чиглэлийн өсвөр үхэр бордох”, “ингэний сүүг өрхийн түвшинд цахилгаан саалтуураар бэлтгэх”, “хонины ноосон бордоо бэлтгэх” зэрэг төслүүд багтсан бөгөөд эдгээр нь малчдын орлогыг өсгөхөөс гадна хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн суурь тогтолцоог бий болгох томоохон ач холбогдолтой. Мөн энэ үеэр малчдын олон жил хүсэн хүлээсэн “Махны чиглэлийн өсвөр үхэр бордох ферм байгуулах” төслийн санхүүжилтийн гэрээг албан ёсоор баталгаажуулснаар төслийн эхлэл тавигдлаа.

Дундын хоршоо 375 сая төгрөг, “Оюу Толгой” ХХК 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тохиролцсон нь орон нутаг-иргэд-компаний хамтын ажиллагааны бодит илэрхийлэл болов.



Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйд суурилсан загвар фермерийн аж ахуй бий болж, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж нээгдэнэ. Үр дүнд нь малчдын орлого нэмэгдэж, орон нутгийн эдийн засагт шинэ эх үүсвэр бий болж, хөдөөгийн хөгжлийн тогтвортой суурь тавигдах юм.

Энэ бол нэг удаагийн гэрээ бус — хамтын оролцоо, итгэлцэл, нутгийн хөгжилд чиглэсэн бодит нөлөөллийг бий болгох үрт хугацааны түншлэлийн эхлэл юм.

“МАХНЫ ЧИГЛЭЛИЙН ӨСВӨР ҮХЭР БОРДОХ ФЕРМ” ТӨСӨЛ

Махны чиглэлийн өсвөр үхэр бордох ферм байгуулах төслийн гэрээнд гарын үсэг зурсан явдал нь дундын хоршоогоор дамжин хэрэгжих төслүүдийн хамгийн эхнийх нь болж байгаа бөгөөд Ханбогд сумын малчид төдийгүй нийт иргэд үр шимийг нь хүртэх мал аж ахуйн томоохон төслүүдийн эхлэл болж буй юм.

ИНГЭНИЙ СҮҮГ ӨРХИЙН ХЭМЖЭЭНД ЦАХИЛГААН СААЛТУУРААР БЭЛТГЭХ ТӨСӨЛ

ГТЗ-ийн шийдвэрийн дагуу энэхүү төслийг тодорхой шалгууруудыг хангасан нийт 56 өрхийн хүрээнд хэрэгжүүлэхээр тохиролцсон. 2025 онд төслийн эхний шатны хүрээнд 15 айлыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлж эхэлснээр олон тооны ингэ саадаг малчин өрхүүдийн саалийн ажиллагааг хөнгөвчилж, ингэний сүүний гарцыг нэмэгдүүлэн, малчдад малынхаа үр шимийг бүрэн дүүрэн хүртэх боломжийг олгож байгаа юм.

Дараагийн 41 өрхийг 2026 оны төлөвлөгөөнд тусган төслийг үргэлжлүүлэхээр болсон. Төслийн хүрээнд нийлүүлэх тоног төхөөрөмж нь дундын хоршооны өмчид бүртгэгдэх бөгөөд Ханбогд сумын нийт малчин өрхүүд хоршоонд гишүүнчлэлтэй болох замаар төслийн үр өгөөжийг хамтдаа хүртэх боломж бүрдэх юм.



1.4 ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУРАЛ, СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭ

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Гурван талт зөвлөлийн дүрэмд заасны дагуу тайлант онд зөвлөлийн хурлыг бүх гишүүдийн оролцоотойгоор 2, 4, 5, 6, 9-р саруудад тус тус хуралдаж, 2025 онд нийт 5 удаа, удирдах нэгж нийт 13 удаагийн хурал зохион байгууллаа. Эдгээр хурал, уулзалтаар цаг үеийн асуудлыг хэлэлцэхээс гадна хэрэгжилт удааширч буй төсөл арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх, зөвлөлийн хурлын тов тогтоох, хараат бус нарийн бичгийн байгууллагыг сонгох, хурлаар хэлэлцэх асуудал, хөтөлбөр бэлтгэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Мөн зөвлөлийн гишүүд 2025 онд 2 удаа Оюу Толгой ХХК-ийн удирдлагуудтай уулзалт хийж, малчдын гомдол барагдуулах гэрээний нийтийн нөхөн олговрын төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Манлайн шороон замын засвар үйлчилгээг сайжруулах шаардлагатай байгаа талаар зөвлөл хэлэлцэв.



1.5 ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ХАЯГДЛЫН ДАЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

Ханбогд сумын Засаг даргын тамгын газар, Гурван талт зөвлөлийн төлөөлөл, Мөнх ногоон Галба ТББ, Говийн газар шороо ТББ болон далангийн ойролцоо нутагладаг малчдын төлөөллөөс бүрдсэн баг Оюу толгой уурхайн хаягдлын далан 1-ийн шүүрлийн засаж залруулах арга хэмжээний биелэлт, мөн Баяжуулах үйлдвэрийн тунгаагуур, хаягдлын далан 1, 2, шүүрлийн ус эргүүлэн татах худаг, шүүрлийн түгжээс далангийн хийцэл, ОТМБ 16-79 цооногийн хэмжилтийн үр дүнтэй танилцлаа.



Хаягдлын далангийн шүүрлийн мониторингийн цэгүүд дээр очиж танилцав



Гурван талт зөвлөлийн малчдын төлөөлөл Оюу толгой уурхайн үйл ажиллагаатай танилцав.

АЖЛЫН ТАЛБАР:

- Хаягдлын далангийн шүүрлийн мониторингийн цэгүүд
- Хаягдал хадгалах сангийн шүүрэл цуглуулах хэсэг, Хаягдал хадгалах 2-р далангийн ашиглалт, Хаягдал хадгалах 1-р далангийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал



Хаягдлын далангийн талаар мэдээлэл танилцуулсан уулзалт

Зөвлөлийн гишүүдийн энэхүү дээрх нөхцөл байдалтай танилцсан нь уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны эрсдэл бууруулах арга хэмжээг үнэлэх, ил тод байдлыг хангах, малчдын итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ байлаа.

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛУУД БОЛОН ЯВЦЫН МЭДЭЭЛЛИЙГ МАЛЧДАД ХҮРГЭВ



2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гурван талт зөвлөл нь малчдад чиглэсэн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор хэд хэдэн талбар уулзалтыг зохион байгууллаа. Тухайлбал, Оюу толгой-Тавантолгой чиглэлийн 12.5 км хатуу хүчилттай автозамын малын гармын байршил, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, хуучин шороон замын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө зэрэг чухал мэдээллийг уул уурхайн бүс орчимд оршин суугаа малчдад танилцуулсан. Уг уулзалтад Оюу Толгой ХХК-ийн төлөөлөл, Жавхлант багийн засаг даргын баг, Гурван талт зөвлөлийн гишүүд оролцож, малчдын асуултад газар дээр нь хариулт өгч, нэмэлт санал хүсэлтийг нэгтгэн авч ажиллав.

Оюу толгой ХХК-ийн төлөөллүүд болон орон нутгийн засаг захиргааны төлөөллүүд малчдад мэдээлэл хүргэж буй байдал.



ОЮУ ТОЛГОЙ ХХХ-ИЙН ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТСЭЭС МАЛЧДАД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭЛЭЭ

- » Ханбогд сумын 4 багийн хуралд 2 удаа оролцож нийт 590 орчим малчин өрхүүдэд Байгаль орчин, далан гэх мэт Оюу толгойн үйл ажиллагаатай холбоотой шинэчилсэн мэдээлэл өгч, орон нутгийн харилцааны хэлтсийн мэдээллийн хуудас тарааж иргэдийн сонирхсон асуултад хариулав.
- » 2025 онд нийт 308 удаагийн үүлзалтаар 786 иргэнтэй ганцаарчилсан болон бүлгийн үүлзалт зохион байгуулсан байна.



Эдгээр мэдээлэл өгөх үүлзалтууд нь малчдын өдөр тутмын амьжиргаа, малын бэлчээрт нөлөөлөх боломжтой зам, дэд бүтцийн ажлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, мөн шийдвэр гаргалтад оролцогч талуудын харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой үүлзалтууд боллоо.

ХАНБОГД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОЖ МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭВ

Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаа, Оюу толгой уурхайн хаягдлын далангийн одоогийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Гурван талт зөвлөлийн ахлагч С. Дорждэрэм (Оюу толгой компаний Орон нутгийн харилцааны дэмжлэг түншлэлийн менежер), Н. Батзориг (Оюу толгой компаний Хаягдлын далангийн ахлах ажилтан) өгөв. Мөн төлөөлөгчдийн сонирхсон асуултад хариуллаа. Энэхүү үүлзалт нь орон нутгийн төлөөллийн байгууллагууд уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээллийг шууд эх сурвалжаас авах, мөн зөвлөлийн ил тод байдлыг хангаж байгаа алхам юм.



Ханбогд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал



1.6 ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН САЙН ТУРШЛАГАА ХУВААЛЦАВ

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ТӨЛӨӨЛЛҮҮД ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ, ТУРШЛАГА СУДЛАВ

Ашигт малтмал, газрын тосны газрын (АМГТГ) төлөөлөл 2025 оны 09 дүгээр сард Ханбогд суманд ажиллах үеэр зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулав. Бүсийн төлөөллүүд зөвлөлийн сайн туршлагаас судалж, тухайн бүс нутгийн онцлогт тулгуурлан хэрхэн зохион байгуулалт хийх, анхаарах асуудал болон зөвлөл байгуулагдсанаар бий болсон давуу тал, сорилтуудын талаар хэлэлцэж санал солилцов.

АМГТГ-ын төлөөллийн зүгээс Гурван талт зөвлөлийн ажил нь уул уурхайн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх, нутгийн иргэдийн оролцоог бодитоор нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтад олон талын тэнцвэртэй байдал хангах сайн жишээ болж байгааг тэмдэглэн, цаашид бусад бүс нутгуудад ижил төстэй загварыг нэвтрүүлэх боломжийн талаар санал солилцсон нь энэхүү уулзалтын гол үр дүн байлаа.



Гурван талт зөвлөлийн гишүүд Рио Тинтогийн Казакстан дахь хайгуулын төслийн мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж зөвлөлийн сайн туршлагаа хуваалцлаа.



1.7 СУДАЛГААНЫ ҮР ДҮНГҮҮД

ХАНБОГД СУМЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТЫН УС ХАНГАМЖИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН 1-Р ШАТНЫ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАВ

2024 онд “Ханбогд сумын хөдөө аж ахуйн ус хангамжийн тогтвортой байдлын судалгаа”-г Монголын гидрогеологи, геоэкологийн холбоо гүйцэтгэв. Судалгаанд газрын доорх усны байршил, чанар, нөөц, малын усны хэрэглээ болон ундны усны аюулгүй байдал зэргийг хамруулсан. Судалгаанаас дараах гол үр дүнгүүдийг гаргасан:

- Ханбогд сумын хэмжээнд тариаланд тохиромжтой газар үндсэн дээ бараг байхгүй бөгөөд усны хамгийн гол хэрэглэгч нь мал аж ахуй болох нь тогтоогдсон юм.
- Малчдын 96 гаруй хувь нь мал усалдаг худгаас ундны усаа авч хэрэглэдэг.
- Шинжилгээнд хамрагдсан 56 усны сорьцын 96.4%-д хүнцэл (arsenic) стандарт хэмжээнээс давсан нь тогтоогдсон. Энэ нь газар доорх говь нутгийн чулуулагт агуулагдах бодис уусаж усанд ордогтой холбоотой бөгөөд геологийн давхаргын байгалийн бүтэцтэй холбоотой гэдгийг тайлбарлав.
- Тиймээс усыг унданд хэрэглэхийн өмнө шүүж цэвэршүүлэх, энгийн хямд аргаар шүүлт хийх нь хүний эрүүл мэндийг хамгаалахад чухал гэж зөвлөсөн.
- Газар доорх усны нөөц нь хязгаартай, ихэнх хөрсний усны эх үүсвэр нь голчлон 40-120 метрийн гүнд байрлаж байгаа бөгөөд зарим бүсэд ус барих давхарга нимгэн, ундны усны эх үүсвэр тогтворгүй байна.
- Цаашид мал услах худаг, усан хангамжийг нэмэгдүүлэх, ашиглалтын усны чанарыг тогтмол хянах шаардлагатай гэж үзсэн.

Үүнээс харахад сумын хэмжээнд ундны болон малын усны аюулгүй байдалд анхаарах, ус цэвэршүүлэх дэвшилтэт болон орон нутгийн нөхцөлд тохирсон хямд аргыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Газрын доорх усны хангамжийг хамгаалж, хэт ашиглалтаас сэргийлэх нь малчдын амьжиргаанд чухал ач холбогдолтой юм.

ГҮНИЙ УУРХАЙН СУУЛТЫН БҮСТЭЙ ХОЛБООТОЙ БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАВ

Ramboll компанийн гүйцэтгэлээр 2022, - 2023 онуудад Гүний уурхайн суултын бүсийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) хийгдэж, уг үнэлгээний үр дүн, төслийн тайланг Гурван талт зөвлөл болон орон нутгийн малчдад танилцуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж дууссан. Энэхүү үнэлгээ нь гүний уурхайн олборлолтын улмаас газрын хэвлийд үүсэж болзошгүй суултын нөлөөлөл, түүнтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох зорилготой.

Үнэлгээний үр дүн, гол мэдээллийг иргэд, малчдад үе шаттайгаар хүргэсэн бөгөөд эхний шатанд

“Гүний уурхай гэж юу вэ?”, “Яагаад суулт үүсдэг вэ?” зэрэг суурь ойлголтыг өгсөн. Үүний дараагаар суултын бүст үүсэж болох байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн талаар - тэр дундаа орон нутгийн амьжиргаа, байгаль орчны өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөх тухай мэдээллийг танилцуулсан.

Олон нийтэд мэдээлэл түгээх ажлын хүрээнд иргэдийн нийтийн болон багийн хурлууд, Оюу толгой ХХК-с зохион байгуулсан арга хэмжээнүүд гэх мэт 280 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгийн үеэр малчид, иргэдийг мэдээллээр хангасан бөгөөд мөн малчдын сонирхсон асуултад зохих мэргэжилтнүүд газар дээр нь хариулж иргэд малчдад мэдээлэл хүргэсэн байна.



Оюу толгой ХХК-ийн төлөөлөл О.Энх-Ариунаа БОННУ-ийн тайланг танилцууллаа.

Энэхүү нэмэлт БОННУ-н цар хүрээнд дараах бүрэлдэхүүнийг хамруулан үзнэ:

- Суултаас үүдэлтэй уурхайн бүсийн тэлэлт: 2030 он гэхэд уурхайн бүсийг өргөтгөх шаардлагатай хязгаарыг тодорхойлсон бөгөөд энэ нь газар ашиглалт, хашаалах бүсийн зохион байгуулалтад нөлөөлөх юм.
- Дугатын голын гольдролын өөрчлөлт: Суултын бүсэд хамрагдах төлөвтэй байгаа тул гольдролыг өөрчлөх шаардлагатайг тайлбарлаж, байгаль орчин болон нийгэмд хамгийн бага сөрөг нөлөө үзүүлэх хувилбарыг сонгохоор ажиллаж байна. Байгаль орчны яам энэхүү үнэлгээг баталсны дараагаараар Дугатын голын гольдролыг өөрчлөх төслийн ажил зураг төслийнхөө дагуу албан ёсоор эхлэх юм.
- Уурхайн талбайн зарим байгууламжийг шилжүүлэн байршуулах ажил: Уурхайн бүсийн тогтвортой, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор гүний уурхайн суулт үүсэх магадлалтай бүсэд байрлаж буй хэд хэдэн байгууламжийг шинэ байршилд шилжүүлэхээр төлөвлөөд байна.

Гүний уурхайн суултын бүсийн үнэлгээ нь уурхайн үйл ажиллагааны урт хугацааны нөлөөллийг зөв тодорхойлох, малчдын аюулгүй байдал, мал аж ахуй эрхлэлт, байгаль орчны эрсдэлийг урьдчилан тооцох, шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой судалгаа боллоо.

УУРХАЙН ХАЯГДЛЫН ДАЛАНГИЙН ШҮҮРЛИЙГ ЗАСАЖ ЗАЛРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЯВЦЫН ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАВ

“Оюу толгой” ХХК нь уурхайн хаягдлын сангийн зүүн талд гарсан усны шүүрэлтэй холбоотой байгаль орчны зөрчлийг засах зорилгоор 2022 оноос эхлэн хэд хэдэн ажил хэрэгжүүлж байна.

Үүний дагуу засаж залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний явцын мэдээллийг ГТЗ-ийн улирал тутмын хурлаар танилцуулдаг. Хяналт шинжилгээний үр дүнгээр шүүрэл уурхайн лицензийн талбайгаас хол яваагүй, усны бохирдлын түвшин хязгаарлагдмал байгааг тогтоосон.

2025 оны 2-руилрлын байдлаар нийт 12 арга хэмжээний 10 нь бүрэн хэрэгжсэн бөгөөд үр дүн нь гарч эхэлсэн байна. Хаягдлын далангийн зураг төсөл, ашиглалтын хэсгийн барилгын ажил, мөн зүүн талын шүүрлийн санг сайжруулах ажлыг бүрэн хийж дуусгасан байна. Хор судлалын судалгаа, изотоп судалгааны өгөгдлийн шинжилгээ (эх үүсвэр, шинж тэмдэг), шүүрэл дамжиж байгаа зам, ус цэвэршүүлэх хувилбарын үнэлгээ зэрэг бүх томоохон судалгаа, шинжилгээ дуусаж, холбогдох өгөгдөл цуглуулах, үнэлгээний ажил хийгдэж байна.

ХИЙГДСЭН ГОЛ АЖЛУУД

- **Автомат систем:** Шүүрэл цуглуулах системийг сайжруулж, зүүн талын сангийн усыг тогтмол хянах автомат систем нэвтрүүлсэн.

Энэ системийн тусламжтайгаар усны түвшин зорилтот хэмжээнээс давахад анхааруулга илгээдэг болж, шүүрхай арга хэмжээ авах боломжтой болсон.

- **Френч дрейн систем:** Френч дрейнд хуримтлагдсан усыг жижиг насосоор татаж, зүүн талын шүүрэл цуглуулах сан руу шахах ба тунгаагуурын усны түвшнийг тогтмол 1135.8 метрээс доош барьсан.

Френч дрейн системийн усыг хянах, шахах ажиллагаа сайжирсан бөгөөд татагдах усны хэмжээ буурч байна.

- **Изотопын шинжилгээ:** Хяналт, шинжилгээ судалгааны үр дүнгээр шүүрэл нь байгалийн болон инженерийн гаралтай ус холилдсон байгааг, харин хаягдлын сангийн шүүрэл маш бага (<10%) хувь эзэлж байгааг тогтоосон.

- **Хаягдлын далангийн зураг төсөл, барилгын ажил**

2025 оны 1-р улирлын байдлаар барилгын бүх томоохон ажлыг хийж дуусгасан тухай мэдээлсэн. 2025 оны 2-р улиралд зүүн талын шүүрлийн санг дахин хэлбэржүүлэх, сайжруулахтай холбоотой нэмэлт барилгын ажил дахин хийгдсэн. Хаягдлын сангийн системийг ажиллуулах явцад шүүрлийг оновчтой хянах, системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зүүн талын шүүрэл цуглуулах сан, френч дрейний усыг зохистой түвшинд барьсан.

- **Зүүн талын тунгаагуурыг сайжруулах төслийг хэрэгжүүлсэн.**

Шүүрэл цуглуулах сангийн бүтэц, бүрэн бүтэн байдлыг удаан хугацаанд тогтвортой байлгах зорилгоор малталт, налууг хэлбэржүүлэх ажил хийгдсэн. Эвдрэл элэгдлийг бууруулах, гадаргын ус зайлуулах нөхцөлийг сайжруулахын тулд хэлбэржүүлж, зассан налуу дагуу хайрга дэвссэн.

- Олон нийт, орон нутгийн байгууллагуудтай харилцаа, мэдээлэл солилцоог тогтмол хийж, тайлангаа цахимаар нээлттэй байршуулж байна.



Дээрх ажлууд нь шүүрлийн тархалтыг хязгаарлаж, уурхайн хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг сайжруулах, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах зорилготой стратегийн арга хэмжээ юм.

1.8 ХААЛТЫН АУДИТ

“Оюу Толгой” ХХК төслийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотойгоор уурхай орчмын 89 малчин өрхтэй 2011, 2012 онуудад 5 жилийн хугацаатай нөхөх олговрын гэрээг байгуулсан. Ийнхүү малчидтай байгуулсан нөхөх олговрын гэрээний хугацаа 2016-2017 онд дуусгавар болж Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хяналт-шинжилгээний хуваарьт тусгагдсаны дагуу гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн үр дүнгийн үнэлгээг хийлгэсэн. Уг үнэлгээгээр амьжиргаа нь:

- 11 өрхийн амьжиргаа 2011 оны түвшнээс хангалттай сайжраагүй гэж дүгнэгдэв.
- “Оюу Толгой” ХХК-аас ундны үс зөөвөрлөн хэрэглэдэг байсан 5 өрх тусгай үнэлгээнд хамрагдав.
- Эдгээр 16 өрхтэй зөвлөмжийн дагуу компанийн зүгээс хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулжээ.

2024 онд хөндлөнгийн байгууллагаар хийсэн хаалтын аудитын эцсийн тайлан 2025 оны 1-р улиралд оролцогч талуудад танилцуулагдсан бөгөөд зөвлөмжүүдийг цаашдын төлөвлөлтөд тусгах ажлыг Гурван талт зөвлөл хариуцан ажиллаж байна.

2011 онтой харьцуулахад сайжраагүй 11 өрх болон “Оюу Толгой” ХХК-аас үс зөөвөрлөж байсан 5 өрхтэй зөвлөмжийн дагуу хамтран ажилласан бөгөөд эдгээр өрхийн хаалтын аудитыг 2024 онд мөн хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, үнэлгээний тайланг 2025 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэгч байгууллага оролцогч талуудад танилцуулав. Цаашилбал Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн Малчдын гомдол барагдуулах гэрээний нийтийн нөхөн олговрын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр шимийг нийт малчид хүртэнэ. Тиймээс тус тусын баг болон Дундын хоршооны гишүүн болох, хоршоодын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох, мөн “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сан болон Хурдасгуур сангийн хүрээнд Ханбогд сумын бизнес эрхлэгчдэд хандсан сургалт, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдэд оролцох боломжууд нээлттэй байна.



1.9 ХАРААТ БУС НАРИЙН БИЧГИЙН БАЙГУУЛЛАГА АЖИЛЛУУЛЖ ЭХЛЭВ



ГТЗ-ийн үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай, хүртээмжтэйгээр зохион байгуулах зорилгоор хараат бус нарийн бичгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэн ГТЗ-ийн шийдвэрээр хараат бус нарийн бичгийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг 2025 оны төлөвлөгөөнд тусгасан.


Тус төлөвлөгөөний дагуу тендерийн сонгон шалгаруулалт зохион байгуулж, түүний үр дүнд “Хөгжлийн Шийдэл” төрийн бус байгууллага шалгаран, ГТЗ-ийн хараат бус нарийн бичгийн байгууллагаар ажиллахаар боллоо. “Хөгжлийн Шийдэл” ТББ нь жижиг, дунд бизнес эрхлэгчид, гарааны бизнес, малчид, төрийн бус байгууллагуудад чиглэсэн бизнесийн зөвлөгөө, сургалт, мониторинг, судалгаа хийх, бизнесийн хамтын ажиллагаа, танилын сүлжээг өргөжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлдэг бөгөөд энэ салбарт 17 жилийн арвин туршлагатай байгууллага юм.

Тус байгууллагаас нарийн бичгийн болон чиглүүлэгч ГТЗ-ийн үйл ажиллагаанд хамтран ажиллах бөгөөд нарийн бичгийн М.Бадамханд, чиглүүлэгчээр Б.Гангис нар томилогдон ажиллахаар боллоо.

1.10 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

- ГТЗ-ийн албан ёсны и-мэйл (tripartitecouncil.kb@gmail.com) хаягийг ГТЗ-ийн нарийн бичгийн ажилтан хариуцан ажиллаж байна.
- Түүнчлэн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2025 онд Ханбогд сумын 4 багийн малчдыг төлөөлсөн гишүүдээр дамжуулан ГТЗ-өөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээ болон цаг үеийн мэдээллийг хэвлэмэл тайлан хэлбэрээр бэлтгэж малчин өрх, оролцогч талуудад хүргүүлэв.







Гурван талт зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг <http://tpc.mn/> цахим хуудаснаас



Гурван талт зөвлөлийн албан ёсны фейсбүүк хуудас [Гурван талт зөвлөл/Tripartite Council](#)

1.11 САНАЛ ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2025 онд ГТЗ-д хандан, орон нутгийн 2 малчидаас ажлын байр болон Ундайн ахмадын өв соёл хөтөлбөртэй холбоотой ирүүлсэн хүсэлтүүдийг зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэн хариуг нь хүргүүлэв.

02 ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1 ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ЗӨВЛӨЛИЙН ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА

Гурван талт зөвлөлийн засаглалын хэрэгжилт болон “Малчдын Гомдол Барагдуулах Гэрээ-1,2”-ийн биелэлтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг 2025 онд төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах тендерийн процесс үргэлжилж байна. Уг үнэлгээгээр Малчдын гомдол барагдуулах гэрээ 1, 2-ын хэрэгжилт, гэрээний үр дүнг баримт нотолгоонд тулгуурлан хараат бус байдлаар үнэлэх, мөн ГТЗ-ийн үйл ажиллагаа нь дүрэм, хууль тогтоомж болон холбогдох олон улсын практик, стандартуудтай хэрхэн нийцэж ажилласныг дүгнэх юм.

2.2 2025 ОНД ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

2.2.1 БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖ

Гурван талт зөвлөл “Малчдын гомдол барагдуулах гэрээ”-ний хүрээнд хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулах арга хэмжээг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Үүний Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр тохирсон ажлын хүрээнд 2025 онд эвдэрч муудсан худгуудыг сэргээн засварлах, технологийн худаг шинээр гаргах, малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Худаг засварлах болон шинээр гаргах, нарны толь суурилуулах хүсэлтэй малчдын худгийг сонгохдоо Ханбогд сумын багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. 2025 оны хувьд ажлын хэсэг худаг тус бүрээр явж хэмжилт, судалгаа хийн тайлан гаргасны үндсэн дээр тухайн худаг нэг бүр дээр хийгдэх ажлын даалгаварыг нарийн тодорхойлсон нь онцлог байлаа. Гүйцэтгэгчийг “Оюутолгой” ХХК-иас жил бүр орон нутгийн хүрээнд тендерийн сонгон шалгаруулалтаар сонгодог бөгөөд 2025 онд:

- Баян Гурван-Эрдэнэ ХХК,
- Дуутын Цагаан Уул ХХК,
- Өмнийн Говийн Солар Энержи ХХК тус тус шалгарсан. 2025 онд Ханбогд сумын 4 багийн хэмжээнд нийт 8 технологийн худаг, 12 гар худгийг сэргээн засварлах, 12 худагт нарны толь суурилуулах ажил хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

Эдгээр ажлууд нь малчдын бэлчээрийн усан хангамжийг тогтвортой болгох, ундны усны хүртээмжийг сайжруулах, худаг бүрийн ашиглалтын хугацааг уртасгах стратегийн ач холбогдолтой юм.



Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төслийн ажлын хэсэг



2019 оноос хойш бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил:

- Нарны толь суурилуулалт 58 худаг
- Гар худаг засвар 100 худаг
- Технологийн худаг /хүдгийн байшин, нарны тольтой/ 28
- Гүний худаг /хүдгийн байшинтай/ 14

МАЛЧДЫН ГҮН ӨРМИЙН ХУДАГТ НАРНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР АЖИЛЛАДАГ УС ӨРГҮҮРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ АЖИЛ

2025 онд уг ажлыг “Өмнийн говийн солар энерги” ХХК гүйцэтгэхээр болсон бөгөөд 8 худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах юм. Нарны толь суурилуулсан нийт хүдгийн тоо /өрхөөр/

Хэрэгжсэн он	Хүдгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2022	22	“Оюу толгой” ХХК	Женераллайтас компани
2023	20	“Оюу толгой” ХХК	Батсэтгэл компани
2024	8	“Оюу толгой” ХХК	Женераллайтас компани
2025	12	“Оюу толгой” ХХК	Өмнийн говийн солар энерги компани
Нийт	58		

МАЛЧДЫН ГАР ХУДАГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛ

Уг ажлын хүрээнд хуучин эвдэрч муудсан худгууд болон зун намрын отрын бүсийг усжуулах зорилгоор малчдын гар худгийг сэргээн засварлах ажлыг 2019 оноос гүйцэтгэж байна. 2024 оны байдлаар нийт 88 гар худгийг сэргээн засварлаад байгаа бол 2025 онд дахин 12 худгийг засварлахаар төлөвлөсөн. Ханбогд сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг засварласан худгуудыг хүлээн авч худаг эзэмшигч малчдыг байлцуулан, гүйцэтгэлийн чанарт тэдний саналыг тусгаж ажилладаг. 2025 оны гар худаг засварын гүйцэтгэгчээр “Дуутын Цагаан Уул” ХХК ажилласан.

Гар худаг сэргээн засварласан нийт тоо

Хэрэгжсэн он	Хүдгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2019	16	Худаг эзэмшигч “Оюу толгой” ХХК	4 Хоршоо, 1 ТББ
2020	20	“Оюу толгой” ХХК	Ханжавхлант компани
2021	20	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2022	16	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2023	8	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2024	8	“Оюу толгой” ХХК	Батсэтгэл компани
2025	12	“Оюу толгой” ХХК	Дуутын Цагаан Уул компани
Нийт	100		

ТЕХНОЛОГИЙН ХУДАГ

Гурван талт зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлж буй ажлуудын нэг нь худгийн ундаргыг нэмэгдүүлэх, үерийн хүчтэй урсгалд худгийн ам дарагдахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй технологийн худгийн ажил юм. 2022 оноос хойш зөвлөлийн зүгээс санаачлан нийт 28 худгийг байшин болон нарны тольтой цогц хэлбэрээр дахин шинэчилэсэн. Энэ нь малчдын эдийн засагт хэмнэлттэй, ажлыг хөнгөвчлөх зэрэг ач холбогдолтой ажил юм. 2025 онд технологийн худгийн ажлын гүйцэтгэгчээр “Баян Гурван-Эрдэнэ” ХХК шалгараад байна.

Хэрэгжсэн он	Худгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2022	4	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2023	16	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2024	8	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2025	8	“Оюу толгой” ХХК	Баян Гурван-Эрдэнэ компани
Нийт	28		

ГҮНИЙ ХУДАГ ГАРГАХ

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан гүн дагуу гүний өрмийн худаг шинээр гаргах ажлыг Эрдэнэ дриллинг компани гүйцэтгэсэн бөгөөд 2025 онд тухайн 3 байршилд гаргасан гүний худаг дээр худгийн байшин, мотор, ус нөөцлөх сав, худгийг онгоц суурилуулах ажлыг орон нутгийн Баян Гурван эрдэнэ компани амжилттай гүйцэтгэж хүлээлгэн өгөв.

Хэрэгжсэн он	Худгын тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2023	10	“Оюу толгой” ХХК	Эрдэнэ дриллинг компани
2024	4	“Оюу толгой” ХХК	Эрдэнэ дриллинг компани
Нийт	14		



Баян баг – Хар овоо байршилд барьсан гүний худаг



Ажлын хэсгийн ахлагч, гүйцэтгэгч компанийн төлөөлөл



Гавилууд баг – Хулгар байршлын гүний худаг



Жавхлант баг – Эрүүн хонд байршлын гүний худаг

2.2.2 УНДАЙН ӨВ СОЁЛ” ТӨСӨЛ



Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настнуудад “Уламжлалт мал аж ахуйн өв, мэдлэгээ залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлуулах сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” зорилго бүхий төслийг 2019 оны 6 дугаар сараас Ханбогд сумын Ахмадын хороотой хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Ундайн голын өв соёл төсөлд хамрагдаж байгаа ахмадууд маань төслийнхөө зорилго үйл ажиллагааг сайтар ойлгож үр хүүхэд ач зээ, гол усныхандаа өөрийнхөө мэддэг чаддаг бүхнээ заан сургаж өвлүүлэхээр чармайн ажиллаж байна. Төслийн танилцуулга болон ахмадуудын яриа, туршлага, сургамжийг олон нийтэд түгээх зорилгоор “Оюу Толгой” сонин, нийгмийн сүлжээ, видео ярилцлагын цуврал байдлаар тогтмол бэлтгэн хүргэж байгаа нь говийн өв соёлын үнэ цэнийг орон нутгийн иргэд төдийгүй олон нийтэд ойлгуулахад чухал нөлөө үзүүлж байна. Төслийн үйл ажиллагааг танилцуулах, таниулах зорилгоор Оюу толгой сонин болон нийгмийн сүлжээ ажиглаж төслийн талаар мэдээлэл болон төсөлд оролцогч ахмад настнуудаас цувралаар яриа бэлтгэж олон нийтэд сар бүр хүргэж байна. Энэхүү төсөл нь 6 жил тасралтгүй үргэлжилж байгаа бөгөөд 2025 оны байдлаар давхардсан тоогоор 430 ахмад настан 15244 гаруй хүмүүст говийн ёс заншил, өв уламжлал, өөрийн амьдралаар олж авсан мэдлэг мэдээллээ залуу хойч үедээ зааж сургаж өвлүүлэн үлдээж байна. Ингэснээр говь нутгийн өвөрмөц соёлын өв болон биет бус өв мартагдаж бүдгэрэн алга болох эрсдэл багасч байна. 2025 оны байдлаар төслийн хамрах хүрээ:

- 430 ахмад настан давхардсан тоогоор сургалтын үйл ажиллагаанд оролцсон;
- Ахмадуудын дамжуулсан сургалт, арга хэмжээ, танилцуулгад 15,244 гаруй иргэн, хүүхэд, залуус оролцож, амьдралын туршлага, бэлчээрийн мал маллах арга ухаан, өв соёлын мэдлэгийг өргөн хүрээтэйгээр олж мэдсэн

Хэрэгжсэн он	Ахмадын тоо /давхардсан/	Сургалтын тоо	Сургалтад хамрагдсан хүний тоо
2020	54	162	1198
2021	55	220	2728
2022	70	267	3178
2023	67	253	2542
2024	74	287	2432
2025	72	154	930
Нийт	430	1609	15244



Энэ төсөл нь зөвхөн ахмад настнуудын мэдлэгийг хойч үед дамжуулах үйл ажиллагаа бус, говийн өвөрмөц соёлын дархлааг бэхжүүлэх, нутгийн иргэдийн бахархлыг нэмэгдүүлэх, залуу үедээ үндэсний үнэт зүйлээ ойлгуулах чухал хөдөлгөөн болж байна. Ундайн голын өв соёл төслийн 6 жилийн үр дүнгээр говийн ахуй соёл, амьдралын ухаан мартагдах эрсдэлээс тодорхой хэмжээнд хамгаалагдаж байна гэж дүгнэж байгаа.

2.2.3 ХӨВ ЦӨӨРӨМ

Малчдын гомдлыг барагдуулах гэрээнд тусгагдсан хиймэл нуур, цөөрөм болон хур борооны ус цуглуулах хөв байгуулах ажлын хүрээнд ГТЗ 2025 онд уг ажлын тооцоо, судалгааг хийхээр төлөвлөсөн. Малчдын гомдлыг барагдуулах гэрээнд туссан усны хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын нэг хэсэг нь, хиймэл нуур, цөөрөм болон хур борооны ус цуглуулах хөв байгуулах юм. 2025 онд Гурван талт зөвлөл энэхүү ажлын техникийн үндэслэл, байршлын үнэлгээг хийхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний хүрээнд судалгааны бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.

Төлөвлөгөөний дагуу ажлын хэсэг байгуулж, Өмнөговь аймгийн Булган суманд ажиллан тус суманд байгуулсан хөв, цөөрмүүдийн хийц загвар, хэмжээ, ашиг тус, үр нөлөөтэй танилцав. Энэхүү судалгаа нь Ханбогд сумын 4 багийн нутаг дэвсгэрт тохиромжтой хөв, цөөрөм байгуулах ажлын загвар, аргачлалыг тодорхойлох чухал түршлага болсон юм. Цаашид хөв, цөөрөм байгуулах ажлыг хэрэгжүүлэхийн өмнө ГТЗ дараах бэлтгэл ажлуудыг хийнэ:

- 4 багийн нутгийн хэмжээнд малчдаас байршлын санал авах;
- тухайн санал болгосон газар бүрт геологийн судалгаа, хөрсний шинжилгээ, уур амьсгалын нөхцөл, ус тогтоох боломжийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлэх;
- судалгааны дүнгийн үндсэн дээр зохистой загвар, хийцийн шийдлүүд боловсруулах;
- төслийн нөлөөлөл, ашиг тусыг малчдад танилцуулан оролцоонд суурилсан шийдвэр гаргах.

Энэхүү суурь судалгаа, бэлтгэл ажил нь Ханбогд сумын усны нөөцийг хамгаалах, хур борооны усыг үр ашигтай ашиглах, бэлчээрийн даацын асуудлыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.



Өмнөговь аймгийн Булган суманд байрлах хөв цөөрөм

2.2.4 НӨХӨН СЭРГЭЭЛТ

ТӨЛӨГИЙН ТАЛД 15га ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙВ

"Мөнх ногоон Галба" ТББ нь Гурван талт зөвлөлийн шийдвэрийн дагуу орон нутгийн иргэд, малчдын оролцоонд тулгуурласан нөхөн сэргээлтийн ажлыг тав дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах хүний нөөцийг 100% орон нутгийн иргэд малчдаар бүрдүүлсэн бөгөөд давхардаагүй тоогоор 79 малчин, давхардсан тоогоор 113 хүн хамтран ажилласан байна. 2025 онд Гавилууд багийн нутаг дэвсгэрт орших Төлөгийн тал дахь 15 га. талбайд нийт 14 төрөл зүйлийн 15,000 ургамлыг суулгацаар тарьж, хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Гялгар дэрс 50,
- Төв азийн лавай 175,
- Говийн тост 67,
- Коржинскийн харгана 517,
- Монгол догар 1046,
- Орог тэсэг 2717,
- Хурц дэлбээт цахилдаг 217,
- Орос махирс 2829,
- Сибирь хармаг 5753,
- Улаанбударгана 300,
- Одой хайлаас 550,
- Үнэгэн сүүлхэй лидэр 517,
- Хулан хойрго 40,
- Олон цэцэгт сүхай 222



Нөхөн сэргээлтийн ажлын явц



Хамтгаалалтын хашаа хийх ажлын явц

Төлөгийн тал нь салхи ихтэй, тал газар түл баруун хойд, хойд хэсгээр салхины хамгаалалт хийх зорилгоор хайлаас, сүхайг тарьж, ургамал ургахад таатай нөхцөлийг бүрдүүллээ.

15 га талбайд тарьсан 15,000 суулгацын усалгааг 20тн багтаамжтай усны машинаар сар бүр тогтмол хийж гүйцэтгэж байна.



Төлөгийн талд 15га талбайд хамгаалалтын хашаа хийх ажлын явц



Усалгаа хийж буй ажлын явц

Эдгээр ургамлууд нь овийн экосистемийн үндсэн бүтэц, уур амьсгалд дасан зохицох чадвар өндөртэй бөгөөд бэлчээрийн доройтлыг бууруулж, хөрсний тогтворжилтыг нэмэгдүүлэх чухал нөлөөтэй. Мөн нөхөн сэргээлтийн ажилд орон нутгийн малчид өөрсдөө оролцсоноор экосистемийн сэргээн засварлалт, байгаль хамгааллын ажлын үнэ цэнийг дээшлүүлэх, иргэдийн байгаль хамгаалах ухамсрыг нэмэгдүүлэх давхар үр нөлөө үзүүлж байна.

УСТ БАГ МОДНЫ 3га ТАЛБАЙН ХАМГААЛАЛТЫН ХАШААГ ЗАСАЖ САЙЖРУУЛЛАА

2025 оны 10-р сарын 27-31-ны өдрүүдэд Ханбогд сумаас баруун урагш 50км зайд орших Жавхлант багийн Уст Баг Модын 3га талбайд труба болон төмөр тор ашиглан хамгаалалтын хашааг 6 ажилтантай хамтран гүйцэтгэв. Энэхүү ажил нь нөхөн сэргээн ургамалжуулах талбайн хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн мал амьтнаас хамгаалан ургамлын ургалт, хөрсний тогтворжилтыг хангах зорилготой юм.



Хамгаалалтын хашаа хийх ажлын явц



Хамгаалалтыг хашааг 3га талбайд хийж дууссан байдал

БОР ОВООГИЙН ЗАДГАЙН УРГАМАЛЖУУЛАЛТ, НӨХӨН ТАРИЛТ

Ундайн голын голдирол өөрчилсөнтэй холбоотой шинэ Бор-Овоогийн задгайн орчимд 2.34 га талбайд ургамалжуулалтын ажил хийсэн. 2017-2020 онуудад нөхөн тарилт, усалгааны ажлуудыг хийсэн.

Тарьсан ургамлууд:

- 2016 онд 8 зүйлийн 1862 ургамал тарив.
- 2017 онд 6 зүйлийн 1405 ургамлаар нөхөн тарилт хийв.
- 2018 онд 5 зүйлийн 560 ургамлаар нөхөн тарилт хийв.



Бор-Овоогийн нөхөн сэргээлт хийсэн талбай

2024 онд “Экоминерал ХХК”-ийн төслийн Бор-Овоогийн задгайн орчимд нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн зарим талбайг мал идэх, малын хөлд талхлагдахаас хамгаалах 762м хашааг угсарч, суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Бор овоо талбайн шинээр хашаажуулалт 2024.10.15

2.2.5 ХАМТЫН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн шийдвэр болон малчдын гомдол барагдуулах гэрээний 3.1-д заасны дагуу байгаль орчны хяналт шинжилгээг иргэд, малчдын оролцоотойгоор шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзсэн. Үүний дагуу Ханбогд сумын иргэд, малчид өөрсдөө сайн дураараа нэгдэж “Мөнх Ногоон Галба” төрийн бус байгууллагыг байгуулсан. Тус байгууллага 2018 оны 8 сарын 1-нээс эхлэн албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлж, “Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ” хөтөлбөрийг өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байна.

Ингэснээр байгаль орчны хяналт шинжилгээ нь зөвхөн байгууллага бус, орон нутгийн иргэд, малчдын өөрсдийнх нь оролцоотой, бодитой, итгэлтэй мэдээлэлтэй болсон нь гол ач холбогдол юм.

1. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Энгийн гар худаг: 2025 оны хагас жилийн байдлаар усны мониторингид 4 багийн 78 малчин хамрагдаж байна. 2024 оны байдлаар хур тунадас их орсонтой холбоотой малчдын отор нүүдэл зогсож, бэлчээрийн ургамал сэргэж, суурин хаваржиж байна.

Энгийн гар худгуудын усны түвшин улирлын байдлаас хамааран 0.01–0.1 метрийн хооронд хэлбэлзсэн байна. Харин хамгийн их өөрчлөлттэй байсан худаг нь Гавилууд багийн малчин Ш.Ганбатын “Дунд Халив” худаг бөгөөд усны түвшин нь 1.6 метр-ээр нэмэгдсэн байна.



Номгон багийн малчин
А.Баяртөр




Номгон багийн малчин
Б.Буяндэлгэр



Баян багийн малчин
Г.Дүгэрсүрэн

Гүн өрмийн худаг: Ханбогд сумын 4 багийн нийт 8 малчны гүний худгийг улирал бүр нэг удаа зөөврийн хэмжилтийн багажаар шалгаж үнэлдэг. Энэ хэмжилтээр худгийн усны түвшин 0.1–0.40 метрийн хооронд өөрчлөгдсөн байна. Эдгээрээс хамгийн их түвшний хэлбэлзэлтэй нь Жавхлант багийн малчин Д.Намсрайн “Зүрх салаа” нэртэй худаг байсан.



Гүн өрмийн худаг хэмжилт



Баян багийн малчин
Р.Бадамдорж

Булаг задгайн мониторинг: Сумын багуудын нутагт байдаг нийт 6 булгийг улирал бүр тогтмол хэмжиж хянаж байна. Өмнөх жилүүдэд хур тунадас бага байсан тул булгуудын ус бага зэрэг татарсан байсан ч энэ жилийн 7, 8-р сарын их борооны дараа өмнө нь татарсан байсан булгуудын ус сэргэж, дахин ундарч эхэлсэн байна.

Оюу Толгойн гүний хоолойн Хяналтын цооног: Гүний хоолойн хяналтын 2 цооногийн усны түвшинг сар бүр тогтмол хэмждэг. Усны түвшний хэлбэлзэл нь 0,05 м-0,9 м хооронд хэлбэлзэлтэй байлаа.

Усны чанарын хээрийн болон лабораторийн шинжилгээ: Усны чанарыг эхлээд хээрийн нөхцөлд усны орчин (pH), эрдэсжилт, цахилгаан дамжуулах чадвар, температур зэрэг үзүүлэлтийг хэмждэг Нанна нэртэй гар багаж ашиглан түргэн шалгадаг. Хэрэв хээрийн хэмжилтээр эдгээр үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдолд тухайн усны дээжийг лабораторийн нарийвчилсан шинжилгээнд оруулдаг.

Энэ жил Оюу Толгойн лицензийн талбайтай ойролцоо байрлах “Дугат”, “Уст баг мод”, “Таван овоогийн ус” гэсэн худгуудын уснаас дээж авсан. Мөн Оюу Толгойн хаягдлын сангийн хяналтын цооног болон Бор овоо уст цэгээс дээж авч, Ханлаб ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид ундны ус болон хүнд металлын шинжилгээ хийлгэж бүрэн үнэлгээ гаргасан.



Жавхлант баг “Таван овоогийн ус” усны дээж авав

1. ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

1.9 Туурайтан амьтны хяналт: Туурайтан амьтны ажиглалт 2025 оны 3,10-р сарын 20 бүрт малчид өөр, өөрийн хариуцсан бүсэд ажиглалт хийсэн. Нийт 865 амьтад ажиглагдсан байна. Үүнд: Хулан, цагаан зээр, бор зээр, янгир, хар сүүлт зээр болон аргаль гэх мэт туурайтан амьтад багтаж байна.

1.10 Мөн Ханбогд сумын бага булаг уст цэгт 14-хоногийн хугацаанд автомат камер байршуулан ажиглалт хийсэн ба Янгир , Шар үнэг ажиглагдсан.



Шар үнэг



Янгир ямаа



Уст цэг



Ногоохон нугас



Өвөгт тогоруу

1. БЭЛЧЭЭРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Номгон, Гавилууд, Жавхлант, Баян багийн нутагт 2025 оны 8-р сарын 11-15-ны хооронд бэлчээрийн судалгааг хийж, нийт 18 цэгт 8 малчинтай хамтран оролцлоо. Судалгаа хийсэн бүх цэгт таних самбар байршуулсан. Энэ судалгаа нь тухайн багуудын бэлчээрийн төлөв байдал, даацын хэмжээ, нөөц боломжийг үнэлэх, цаашдын төлөвлөлтөд ашиглах ач холбогдолтой.



Бэлчээрийн судалгааны ажлын явц

Тоорой модны мониторинг: Уртын голын тоорой төгөл болон Хөх дэлийн тоорой мод-ны мониторингийг 2020 оноос эхлэн тогтмол хийж байна. Энэ ажлыг Жавхлант багийн малчин О.Хоролсүрэн, Б.Бямбадэлгэр нар хамтран гүйцэтгэдэг. 04-10-р сарын хугацаанд сар бүрийн 15-нд судалгааны талбай дахь зулзаган тоорой модны өндрийг хэмжиж, дата, мэдээг боловсруулдаг.

1.11.1 Өвчлөлийг бууруулах арга хэмжээ

- 2025 оны 08-р сарын 9, 10-нд Уртын голын тоорой мод өвчилсөн тул тоорой модны хашааг цэвэрлэж, биологийн хор цацах арга хэмжээ хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээ нь тоорой модны тоо, тархцыг нэмэгдүүлэх, үндсээ булаацалдахаас хамгаалж ургах орчныг сайжруулах зорилготой.

1.11.2 Тоорой модны суулгачын арга хэмжээ

- 2025 оны 04-р сарын 16-нд Уртын голын тооройн төглөөс 100 ширхэг тоорой модны суулгачыг иргэний хүсэлтээр Улаанбаатар хот дахь мод үржүүлгийн газарт өгсөн. Энэхүү суулгачын ажил нь тоорой модны тархцыг нэмэгдүүлэх, ургамлын нөхөн сэргэлтийг дэмжих чухал арга хэмжээ болсон.



Тоорой модны хэмжил



Тоорой модны суулгац

1. ТООСЖИЛТЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

2021 оноос эхлэн 2 малчинтай хамтран тоосны хяналтын хэмжилтийг тогтмол хийж байна. 2025 онд шинэ багажууд болох OIZOM Pollusense, DustTrak™ DRX-ийг ашиглаж эхэлсэн бөгөөд эдгээр нь автомат горимоор өдөр бүрийн тоосны мэдээллийг нарийн бүртгэдэг. 2025 онд суманд хатуу хучилтай зам өргөсгөх, шинэ зам тавих ажил эрчимжсэнтэй холбоотойгоор зарим саруудын тоосжилтын хэмжээ түр хугацаанд өссөн.

- 2025 оны I-р улирлаас эхлэн нийт 9 цэгт тоосны хэмжилт хийхэд Ханбогд сумын төвийн агаар дахь нарийн (PM2.5) болон том ширхэгт (PM10) тоосонцор зарим үед MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан байна. Энэ давалт нь голдуу 4-р сар болон 8-р сард ажиглагдсан.



OIZOM POLLUSENSE болон DustTrak™ DRX Aerosol Monitor багажаа ажиллуулж 24цагийн турш ажиллаж буй зураг

1.12 Уурхайн хаягдлын сангийн хөрсний бохирдлыг бууруулах туршилт судалгаа (Фиторемедиация)

Ханбогд суманд, Оюу Толгой ХХК-ийн хаягдлын сан болон хяналтын 2 цэгт 10×20 метр талбайг хашаалж, хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулах фиторемедиацийн туршилт судалгааг хийж байна. Судалгаанд ашигласан ургамал:

- *Reaumuria soongorica* (Зүүнгарын бутаргана)
- *Nitraria sibirica* (Сибирь хармаг)

96 ургамлыг суулгацаар тарьж, хөрсний бохирдлыг бууруулах үр нөлөөг ажиглаж байна.

05–10-р сарын хугацаанд судалгааны талбай дахь ургамлын өндрийг сар бүр хэмжиж, зургийг авч биологийн хөгжлийг судалдаг.

- Судалгааны 2 цэгээс хөрс болон ургамлын дээжийг 2025 оны 11-р сарын 30-нд авч, Ханлаб лабораторид шинжилгээнд илгээжээ.

Энэ туршилт нь хөрсөнд хуримтлагдсан хүнд металлыг ургамал ашиглан бууруулах шинжлэх ухаанч арга бөгөөд ирээдүйд хөрсний нөхөн сэргээлтэд чухал хувь нэмэр оруулах боломжтой.



Оюу Толгой ХХК-ийн Хаягдал Хадгалах байгууламжийн талбай

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2025 онд Мөнхногоон Галба ТББ нь Ус, ургамал, амьтан, агаарын чанар тоосны мониторингийг Ханбогд сумын багийн малчидтай хамтран хийж гүйцэтгэсэн.

Уртын голын болон Хөх дэлийн судалгааны талбай дахь 17 ширхэг зулзаган тоорой модны ургалт хэвийн бөгөөд амьдрах чадвар 100 хувь байв. Уртын голын тоорой мод, бусад ургамлууд маш сайн ургасан буюу хашаан доторх тоорой мод шигүү ургасан төдийгүй хашааны гадна шинээр хэд хэдэн зулзаган тоорой мод ургасан байлаа. Тоорой мод өвчилсөн байгаа нь ажиглагдсан бөгөөд навчнаас дээж авч шинжлүүлсэн, өвчилсөн шалтгааныг тодорхойлсон.

Ханбогд сумын 4 багийн 80 малчин 2019 оноос хойш 7 дахь жилдээ хэмжсээр байна. Цаг агаар улирлын байдлаас шалтгаалан зарим жилүүдэд хэмжилтийн ажил бага зэрэг тасалдалттай байсан бол сүүлийн жилүүдэд хур тунадас элбэг жилүүд байсан учир хэмжилтийн ажил тасалдалгүй үргэлжилж байна.

Ханбогд сумын 8 гүн өрмийн буюу ерөмдмөл худгийн хэмжилтээс харахад 2025 онд усны түвшин хамгийн их түвшиндээ байлаа. Цаг агаар хур тунадаснаас шалтгаалан усны түвшин нэмэгдэж байгаа байдал ажиглагдаж байна.

Оюу Толгойн хаягдлын сангийн ойролцоох худгууд болон хяналтын цооногоос усны дээж авч ундны ус болон хүнд металлын шинжилгээг хийлгэлээ. Тус шинжилгээгээр Дугат худгийн усны фтор, натри, молибден элементүүд 2021–2025 оны шинжилгээн дээр зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлттэй байлаа.

ОТМВ16–86 цооногийн хүнд металлын шинжилгээгээр 2024 онд маш өндөр үзүүлэлттэй байсан зарим элементүүд 2025 оны шинжилгээгээр буурсан үзүүлэлттэй ба зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна.

Мониторингийн малчдын худгийн мэдээ мэдээллийг цуглуулан ажиллаж байна.

Одоогоор мониторингийн 83 худгаас 43 худгийн мэдээллийг цуглуулсан бөгөөд малчид отор нүүдлээр явсан байгааг харгалзан үзэж байна.

Нарийн ширхэгт тоосонцор 2025 онд 9цэгт хэмжилт хийснээс Сумын төв 1-р цэг нь (хоногийн дундаж агууламж MNS4585:2025) стандартын хязгаарт ойртсон үзүүлэлт гарсан. Энэ нь хатуу хучилттай замын ажил явагдсантай холбоотой. Нарийн ширхэгт тоосонцор нь 2022 онд зарим цэгүүдэд маш өндөр (жишээ нь Сум1 – 99 мкг/м³) гарч байсан бол 2023 оноос буурсан. Харин 2024–2025 онд тогтвортой, стандартын дотор байна.

Том ширхэгт тоосонцор 2025 онд 9цэгт хэмжилт хийснээс Сум1 болон Сумын төв 1-р цэгт (хоногийн дундаж агууламж MNS4585:2025) стандартын хязгаарт ойртсон үзүүлэлт гарсан. Энэ нь замын хөдөлгөөн болон хатуу хучилттай замын ажил явагдсантай холбоотой. Том ширхэгт тоосонцор нь 2023 онд Сумын төв 1-р цэгт маш өндөр (163 мкг/м³) гарсан. Харин 2024–2025 онд буурсан боловч зарим цэгт (Манлай, Сум1) өндөр хэвээр байна.



Гурван Талт Зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг:
trc.mn
Гурван талт зөвлөл/Tripartite Council
tripartitecouncil.kb@gmail.com